



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь хөтөлбөрийн газрын

Байгаль орчны мэдээ

Дугаар: 2006-03-14

Ирвэсний арьс дамлан худалдаалахыг завджээ...

2006 оны 3-р сарын 14-ний өдөр Ховд аймгийн төвд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын иргэн Жекейгийн Жархын цоохор ирвэсний дөрвөн арьс дамлан худалдаалахаар авч явсныг Хууль бус агнууртай тэмцэх Ирвэс-3 баг илрүүллээ. Энэ баг нь 2003 онд Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэйгээр Улсын мэргэжлийн хяналтын газрын удирлаган дор Ховд аймагт байгуулагдсан юм.

Энэ хэргийн эд мөрийн баримт ирвэсийн 4 ширхэг арьс, нэг ширхэг гавлын ясыг Ховд аймгийн Цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн байна. Энэ хэрэгтэй холбоотойгоор фото зураг авах, видео бичлэг хийх, радио ярилцлага авах, сонин хэвлэлд бичих зэргээр өргөн олон нийтэд сэрэмжлүүлэх үүднээс сурталчиллаа. Цагдаагийн хэлтэст хүлээлгэн өгсөн 4 арьсны 3 нь нойтон (алаад удаагүй), 1 нь элдэгдсэн байжээ.

Тус хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Уг хэргийг яаралтай шийдвэрлэх, агнасан эзнийг нь олж тогтоох, ирвэсийг хууль бусаар агнадаг, цааш нь дамлан зардаг, хил давуулан худалдаалдаг сүлжээг арилгах талаар яаралтай арга хэмжээ авах, эрчимтэй мөрдөн шалгах хэрэгтэй байгааг энэ дашрамд сонордуулж бана.